

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06-р сарын 14-ний өдөр

№ 19

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
цахим хэлбэрээр хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дах заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын Хоёрдугаар бүлгийн 2.2, 2.3 дахь заалт, Гуравдугаар бүлэг болон “Инвескор ББСБ” ХК-ийн Дүрмийн 9.6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 14:00 цагт Ковид-19-н цар тахлын эрсдэлтэй үед хувьцаа эзэмшигчдийг нэг дор цуглуулахгүйгээр цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
  - 2.1. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах;
  - 2.2. Компанийн “Дүрэм”-ийн /шинэчлэсэн найруулга/ төслийг батлах;
  - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай;
4. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;
5. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Компани болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор нийтэд мэдээллэж, зарын давталтыг 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээллэсүгэй;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;
7. “Хурлын санал авах хуудас”-ын загварыг энэхүү тогтоолын Гуравдугаар, болон Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай;
8. Компанийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг



Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/, болон Хурал зохион байгуулах комисс /Ш. Эрдэнэбилэг/-д даалгасугай;

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар “Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-г томилсугай;

10. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

10.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:  
Ш. Эрдэнэбилэг Үйл ажиллагаа хариуцсан захирал

10.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:  
А. Энэрэл Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга  
З. Балжиржанцан Ахлах санхүүгийн шинжээч  
А. Билгүүн Санхүүгийн шинжээч  
Э. Манлай Маркетингийн менежер  
Б. Жавхлан Ахлах дизайнер  
М. Хэрлэн Хүний нөөцийн менежер  
Б. Мөнхсүлд Мэдээлэл технологи хариуцсан менежер  
Б. Мөнх-Эрдэнэ Борлуулалт, үйлчилгээний менежер  
Д. Нанзадрагчаа Систем хариуцсан захирал  
Г. Магнайбаяр Ахлах хөгжүүлэгч  
Д. Мөнхцэцэг Үйлчилгээ ажиллагаа хариуцсан захирал

11. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

11.1. Тооллогын комиссын дарга:  
Б. Одхүү Санхүүгийн ахлах менежер

11.2. Тооллогын комиссын гишүүд:  
Б. Дэлгэржаргал Салбар хариуцсан менежер  
Ө. Энхзаяа Ахлах дотоод аудитор

12. Хувьцаа эзэмшигчдийн “Хурлын санал авах хуудас”-ыг үнэт цаасны брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 18:00 цагт тасалбар болгохоор тогтоосугай;

13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/, Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР**



<b>Компанийн нэр:</b>	Инвескор ББСБ ХК
<b>Хурлын төрөл:</b>	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
<b>Хурал хуралдах өдөр, цаг:</b>	2022 оны 07 дугаар сарын 25, 14:00 цагт
<b>Хурал хуралдах газар:</b>	Компанийн веб хаягаар дамжуулан цахим хэлбэрээр
<b>Бүртгэлийн өдөр:</b>	2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр
<b>Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:</b>	<ol style="list-style-type: none"><li>1. Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах;</li><li>2. Компанийн “Дүрэм”-ийн /шинэчлэсэн найруулга/-ын төслийг батлах;</li><li>3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;</li></ol>
<b>Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:</b>	<p>Хувьцаа эзэмшигчид нь 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцаж болно.</p> <p>Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:30-18:30 цагийн хооронд ажиллана.</p>
<b>Хурал хуралдах шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:</b>	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 19 тоот тогтоол.
<b>Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:</b>	<p><b>Хурлын комиссын дарга:</b> Үйл ажиллагаа хариуцсан захирал Ш. Эрдэнэбилэг, <a href="mailto:erdenebileg@invescore.mn">erdenebileg@invescore.mn</a>, 99098785</p> <p><b>Хурлын комиссын гишүүд:</b></p> <ol style="list-style-type: none"><li>1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга А. Энэрэл, <a href="mailto:enerel@invescore.mn">enerel@invescore.mn</a>, 88103947</li><li>2. Ахлах санхүүгийн шинжээч З. Балжиржанцан, <a href="mailto:baljirjantsan@invescore.mn">baljirjantsan@invescore.mn</a>, 90049978</li><li>3. Маркетингийн менежер Э. Манлай, <a href="mailto:manlai@invescore.mn">manlai@invescore.mn</a>, 80004354</li><li>4. Хүний нөөцийн менежер М. Хэрлэн, <a href="mailto:kherlen@invescore.mn">kherlen@invescore.mn</a>, 8809-9340</li><li>5. Мэдээлэл технологи хариуцсан менежер Б. Мөнхсүлд, <a href="mailto:munkhsuld@invescore.mn">munkhsuld@invescore.mn</a>, 99992632</li><li>6. Борлуулалт, үйлчилгээний менежер Б. Мөнх-Эрдэнэ, <a href="mailto:munkherdene.b@invescore.mn">munkherdene.b@invescore.mn</a></li><li>7. Үйлчилгээ ажиллагаа хариуцсан захирал Д. Мөнхцэцэг, <a href="mailto:munkhtsetseg@invescore.mn">munkhtsetseg@invescore.mn</a>, 91915767</li><li>8. Систем хариуцсан захирал Д. Нанзадрагчаа, <a href="mailto:nanzadragchaa@ailab.mn">nanzadragchaa@ailab.mn</a>, 88074844</li></ol>





**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ  
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн жагсаалт
1	“Инвескор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 19 тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4	Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
5	“Инвескор ББСБ” ХК-ийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
6	Компанийн хувьцаа хуваах тухай асуудлын төсөл;
7	Компанийн “Дүрэм”-ийн /шинэчлэсэн найруулга/-ын төсөл;
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга;
9	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах шийдвэрийн төсөл;

\*\*\*\*\*

**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС  
Хэлэлцэх асуудал № 1,2**



Хувьцаа эзэмшигчийн:

Овог: \_\_\_\_\_ Нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокерийн овог, нэр \_\_\_\_\_

Энэхүү Санал авах хуудсаар 2022 оны 07-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Компанийн веб сайтаар дамжуулан цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн “Дүрэм”-ийн /шинэчлэсэн найруулга/-ын төслийг батлах;			
2.	Компанийн хувьцаа хуваах тухай асуудлыг батлах;			

**Санал авах хуудсыг ашиглах санамж:**

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт  тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал тэмдэглэн, үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниад 2022 оны 07 дугаар сарын 22-ний 18:00 цагаас өмнө хүргүүлнэ.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
- Засварласан, балласан, залруулгатай, болон нэгээс олон санал өгсөн санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

Брокерийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

2022 оны \_\_\_-р сарын \_\_\_-ны өдөр



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС  
Хэлэлцэх асуудал № 3**



Хувьцаа эзэмшигчийн:

Овог: \_\_\_\_\_ Нэр : \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: Кумулятив \_\_\_\_\_

Саналын тоо: \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокерийн овог, нэр \_\_\_\_\_

Энэхүү Санал авах хуудсаар 2022 оны 07-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Компанийн веб сайтаар дамжуулан цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
Тогтоол №2		
<b>Ердийн гишүүд:</b>		
1.		
2.		
3.		
4.		
5.		
6.		
<b>Хараат бус гишүүд:</b>		
1.		
2.		
3.		
4.		

**Санал авах хуудсыг ашиглах санамж:**

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт  тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал тэмдэглэн, үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниад 2022 оны 07 дугаар сарын 22-ний 18:00 цагаас өмнө хүргүүлнэ.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
- Засварласан, балласан, залруулгатай, болон нэгээс олон санал өгсөн санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

Брокерийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

2022 оны \_\_\_-р сарын \_\_\_-ны өдөр

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 10 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 10 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 90 саналыг эрхтэй /10\*9 гишүүн=90/ болох бөгөөд үүнээс 60 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 30 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өрөх эрхтэй болохыг анхаарна уу.